



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/34

Мандалговь

┌ Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.12, “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 266 дугаар тогтоол, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Наран багийн нутаг “Майхан хар” /N45.585252/ /E106.1104917/ гэх газарт малын халдварт “Дуут хавдар” өвчин 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр оношлогдож хязгаарлалтын дэглэм тогтоосон 21 хоногт малын өвчлөл илрээгүй тул хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Хязгаарлалтын дэглэм цуцалсан ч малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ард иргэд, малчдыг малын халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (Е.Отгонцэцэг), тархвар зүйч эмч (Д.Эрдэнэцэцэг) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ

4822010017